



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл

Шинэчлэгдэн батлагдсан “Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл олгох журам”-ын тухай


Бэлтгэсэн:

ТЗА-ны ахлах мэргэжилтэн Г. Нарантуяа

2017-05-12



Агуулга:

- *Хууль, эрх зүйн үндэслэл*
 - *Өөрчлөлт оруулах болсон шалтгаан*
 - *Журмын танилцуулга, онцлог*
- 

Техникийн нөхцлийн журам батлах хууль, эрх зүйн үндэслэл



- *Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 9.14, 10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалт, “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн боловсруулсан.*

9.13 Зохицуулах зөвлөл нь бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлыг зөвлөлийн хурлаар хэлэлцэх бөгөөд Зохицуулах зөвлөлийн хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

9.14 Зохицуулах зөвлөлийн шийдвэрийг ТЗЭ, хэрэглэгч дагаж мөрдөнө.

10.1.9 Зохицуулах зөвлөл нь “Техникийн нөхцөл олгох журам батлах”

5.3 Зөвлөлийн хуралдааны шийдвэр тогтоол хэлбэртэй байна.


Өөрчлөлт оруулах болсон шалтгаан

Анхны “Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл олгох журам” нь 2013 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн Зохицуулах зөвлөлийн 36 тоот тогтоолоор батлагдсан.

➔ **Х**эрэглэгчийн хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдаж буй инженерийн шугам сүлжээнээс дараагийн хэрэглэгчийг холбох холболтын тухай нарийвчлан заалт оруулах шаардлага бий болсон.

➔ **Т**ехникийн нөхцлийг дур мэдэн өөрчилсөн, техникийн нөхцөлд тусгасан шаардлагыг зөрчсөн, техникийн нөхцөлгүй болон дур мэдэн холболт хийсэн байгууллага, иргэнд авах арга хэмжээг тодорхой болгох. Түүнчлэн техникийн нөхцлийн тодруулгыг буруу өгсөн албан тушаалтанд тооцох хариуцлагыг тогтоох.

- **Х**ангагч байгууллагуудад одоо мөрдөгдөж буй “Техникийн нөхцөл олгох журам”-ын биелэлт хангалтгүй, үг, найрууллагыг шинэчлэх .
- **У**с хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хэрэглэгчийг холбох MNS 4236:2003 стандарт нь энэхүү журам батлагдан гарсан өдрөөс хойш мөрдөх шаардлагагүй болсон.
- **З**ахиргааны ерөнхий хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан энэхүү журмыг ХЗЯ-р хянуулж, улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлага тулгарсан.



“Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл олгох журам”-ын товч танилцуулга

1. Журмын бүтэц:

- *Нийтлэг үндэслэл*
- *Комиссын эрх, үүрэг*
- *Хэрэглэгчийн эрх, үүрэг*
- *Комиссын үйл ажиллагаа*
- *Техникийн нөхцөл олгоход тавигдах шаардлага*
- *Техникийн нөхцөл олголт*
- *Бусад зүйл*
- *Маягт 1*

Нэмэлт, өөрчлөлт орсон зүйл, заалтууд

Хуучин журам 6 бүлэг 48 заалттай байсныг 7 бүлэг 41 заалт болгон шинэчлэн найруулсан. Үүнд:

- Техникийн зөвлөл-техникийн комисс болгон өөрчлөв.
- **1.6. Комиссын шийдвэрээр техникийн нөхцлийг энэхүү журмын хавсралтад заасан Маягт №1-ээр олгоно.**
-
- **2.5 Хэрэглэгч нь техникийн нөхцлийг дур мэдэн өөрчилсөн, өөрийн эзэмшлийн шугамаас дараагийн хэрэглэгчийг холбуулахаас татгалзсан, техникийн нөхцөлд тусгасан шаардлагыг зөрчсөн, техникийн нөхцөлгүй болон дур мэдэн холболт хийсэн байгууллага, иргэнийг инженерийн хангамжаар хангахаас татгалзах шийдвэрийг техникийн нөхцөл олгох комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй.**
- **3.4 Хэрэглэгч техникийн нөхцөл авахаар хүсэлт гаргахдаа холбуулахаар санал болгож байгаа шугам сүлжээний өмчлөгчтэй зөвшилцсөн байх ба холбогдох байгууллагаас техникийн тодруулга авна.**

4.8 Комиссын нарийн бичгийн дарга нь комиссын шийдвэр, болон холболтын зураг схемийг цахим хэлбэрээр бүрдүүлж байгууллагын архивт хадгалах бөгөөд тухайн орон нутгийн Засаг даргын Тамгийн газарт хүргэх ажлыг зохион байгуулна.

7.2 Техникийн тодруулгыг өгөхдөө шугам сүлжээний ачаалал, хэвийн ажиллагааг хангах зарчмыг баримтлах бөгөөд техникийн тодруулгаас үүдэн гарсан хариуцлагыг техникийн нөхцөл олгосон болон техникийн тодруулга өгсөн байгууллага хүлээнэ.

Дүгнэлт

- **Х**эрэглэгчийн хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдаж буй инженерийн шугам сүлжээнээс дараагийн хэрэглэгчийг холбох асуудал маргаан, хүндрэл дагуулдаг бөгөөд энэхүү журмын нэмэлт, өөрчлөлтөөр уг асуудлыг шийдвэрлэх боломжтой болсон.
- **Т**ехникийн нөхцлийн тодруулгыг дур мэдэн өгч, бодит байдлаас зөрүүлснээс үүдэн гарах маргааныг арилгах, техникийн нөхцөлд тусгасан шаардлагыг зөрчсөн, техникийн нөхцөлгүй болон дур мэдэн холболт хийсэн байгууллага, иргэнд авах арга хэмжээг тодорхой болгож өгөв.
- **Т**ехникийн нөхцөл олгохтой холбоотой харилцааг зохицуулах үндсэн зорилгоо биелүүлэх боломж хангагдсан болно.
- <http://www.legalinfo.mn/annex/details/7485?lawid=12281>

**АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**

